



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2017 • V • № 7



**Н.БАТСАЙХАН: ЭРСДЭЛД
СУУРИЛСАН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ УЛАМ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО**

**ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТ:
ЯАГААД ИНФЛЯЦИ ВЭ?**

**ЖОН БЕЛЛ: БЭЛЭН
БУС ГҮЙЛГЭЭНИЙ
ХЭРЭГЛЭЭНД ҮСРЭНГҮЙ
АХИЦ ГАРЧ БАЙНА**

**ОУВС-ИЙН ӨРГӨТГӨСӨН
САНХҮҮЖИЛТИЙН
ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР
БОЛЛОО**

Монголбанкны Эрдэнэсийн сангаас (Тайлбар 28-р нүүрт)



/Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



/Mongolbankmn



“МӨНГӨН ТЭМДЭГТИЙН СОЁЛТОЙ ХЭРЭГЛЭЭ”
2 САРЫН АЯН ЗАРЛАГДЛАА (V-VII САР)

СОЁЛТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ



Онцлох мэдээ:

5-р сарын онцлох үйл явдлууд

ХУУДАС

4

Ярилцлага:

Н.Батсайхан: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгоно

ХУУДАС

6

Инфографик:

Түүхий эдийн зах зээл

ХУУДАС

9

Инфографик:

Дэлхийн төв банкуудын зорилтууд

ХУУДАС

20

Маркет анализ:

Зэсийн зах зээлийн орчин

ХУУДАС

26

Дэлхийн эдийн засаг:

Актив удирдлагын компани (АУК) олон улсад

ХУУДАС

29

Орон нутаг:

Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс

ХУУДАС

10

Банкир:

Жон Белл: Бэлэн бус гүйлгээний хэрэглээнд үсрэнгүй ахиц гарч байна

ХУУДАС

30

Мөнгөн тэмдэгтийн түүх:

Монгол Улсын албан ёсны анхны мөнгөн тэмдэгт

ХУУДАС

13

Судалгаа:

Хэрэглэгчийн итгэлийн индексийн 2017 оны I улирлын үр дүн

ХУУДАС

34

Асуулт, хариулт:

Монголбанкны 5-р сарын хэвлэлийн хурлаас...

ХУУДАС

16

Хэвлэлийн мэдэгдэл:

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр боллоо

ХУУДАС

38

2017.05.02: Валют арилжааны цахим талбар нээгдэв

Цахим талбарыг нэвтрүүлснээр банк хоорондын валютын зах дахь төлбөр тооцоо, мэдээллийн эрсдэлийг бууруулж, спот ханш бүрэлдэх, валютын захын хүртээмж, ил тод, нээлттэй байдал нэмэгдэх, нөгөөтэйгүүр Монголбанк мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай авч, шаардлагатай үед зах зээлд оролцох, валют арилжааны нэгдсэн талбар бий болгох үндэс суурийг тавих ач холбогдолтой юм.



2017.05.03: Орон нутаг дахь ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авав



Орон нутагт ипотекийн хөтөлбөрийн эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн төлбөрийн хэсгээс 16 тэрбум төгрөгийг орон нутаг дахь банкны салбаруудад олголоо. Цаашид Монголбанкнаас сар тутам олгодог ипотекийн зээлийн эх үүсвэрээр зээлдэгчдийн 25% нь хөдөө орон нутгаас хамрагдсан байх чиглэлийг банкуудад өгөв.

2017.05.12: Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний хурал болов

Эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг дэмжих зорилгоор Монголбанкнаас жил бүр зохион байгуулдаг эрдэм шинжилгээний бага хурлын эцсийн шалгаруулалтыг явуулж, ялагчдыг тодруулав.



2017.05.17: Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав



Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга - хэлэлцүүлгийг иргэд, олон нийтэд нээлттэй хэлбэрээр хийв. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, хуульчид, судлаачид болон олон нийт, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцлоо.

2017.05.19: “Орон сууцны зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг болов

Монголбанк нь “Орон сууцны зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг Засгийн газар, МИК ОССК ХХК, их дээд сургууль болон арилжааны банкны төлөөллүүдтэй хамтран зохион байгуулав.



2016.05.19 Хэн сайн санхүүч болох вэ? АХА тэмцээн болж өндөрлөв



“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк, МУИС-ийн Бизнесийн сургуулийн оюутны эрдэм шинжилгээний “Санхүүч” клуб хамтран “Хэн сайн санхүүч болох вэ?” сэдэвт АХА тэмцээнийг зохион байгуулав. Энэхүү тэмцээн нь “Хувь хүний санхүү” хичээлийг сонгон судалж буй МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын оюутнуудын дунд 3 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа юм.

2017.05.24: “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх шийдвэр батлагдав

Олон улсын валютын сангийн захирлуудын зөвлөл хуралдаж, Монгол Улсад зориулж 3 жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг батлах шийдвэр гаргалаа. Монгол Улсад эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх тус хөтөлбөрийн хүрээнд хийгдэх нийт 5.5 тэрбум ам.долларын хэмжээтэй санхүүжилтэд ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка зэрэг олон улсын байгууллагуудаас гадна Япон, БНХАУ, БНСУ зэрэг 2 талт хамтын ажиллагааны орнууд оролцох болно.



2017.05.25 “Монгол Улс дахь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, эрх зүй зохицуулалтын өнөөгийн орчин ба өөрчлөн сайжруулах зөвлөмж” үндэсний хэлэлцүүлэг болов



Хэлэлцүүлгийг Монголбанк зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи, болон бусад мэргэжлийн холбоод оролцлоо. Азийн хөгжлийн банкнаас “Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих төсөл”-ийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн судалгаа хийгдэж, үүний дагуу зөвлөмж гаргасныг хэлэлцүүлгийн үеэр танилцуулав.



Н.БАТСАЙХАН: ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ УЛАМ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО

Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал Н.Батсайхантай ярилцлаа.

■ **Монгол Улс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах хүрээнд Монголбанкны зүгээс олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний компаниар банкуудад активын үнэлгээ хийлгэхээр болсон. Банкуудад активын үнэлгээ хийх ажлын явц ямар шатандаа байна вэ?**

-Монгол Улс ОУВС-тай хамтран макро эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрсэн. Ойрын хугацаанд уг хөтөлбөрийг батлах байх. Монгол Улс уг хөтөлбөрт хамрагдахын тулд ОУВС-гийн шаардлагын дагуу гурван урьдчилсан нөхцөл, болзлыг хангах үүрэг хүлээсэн. Эдгээр урьдчилсан нөхцөлийн нэг нь банкны салбарын актив хөрөнгийг үнэлэх хөндлөнгийн, олон улсад нэр хүнд бүхий зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлэх юм. Уг сонгон шалгаруулах ажлыг ОУВС-гийн шаардлагын дагуу хугацаандаа эхлүүлсэн бөгөөд энэхүү ажил одоогоор хэвийн үргэлжилж байна.

■ **Активын чанарын үнэлгээ гэдгийг хэрхэн ойлгох вэ, үнэлгээнээс хамаарч цаашдаа банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийгдэх асуудал яригдах байх?**

-Бүтцийн өөрчлөлтийн талаар одоохондоо ярихад эрт байна. Монголбанк энэ оны аравдугаар сар гэхэд хөндлөнгийн аудитын байгууллагаар банкуудад активын үнэлгээг хийж дуусгахаар төлөвлөн ажиллаж

байна. Үүний дараа дүгнэлтээ энэ оны эцэст банкуудад танилцуулж мэдэгдэнэ. Активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдал илрээгүй тохиолдолд банкуудад ямар нэгэн шаардлага тавихгүй. Харин тус үнэлгээгээр банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангахааргүй үр дүн гарах тохиолдолд Монголбанк санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авах болно. Тухайн арга хэмжээ нь өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээнээс шалтгаалахаар байгаа бөгөөд банкинд мэдэгдэл, үүрэг өгөхөөс авахуулаад бүтцийн өөрчлөлт хийх хүртэл арга хэмжээ байж болно. Гэхдээ түрүүн хэлсэнчлэн одоогоор бүтцийн өөрчлөлтийн талаар ярихад хэт эрт байна. Монголбанкны хувьд активын чанарын үнэлгээ нь хөндлөнгийн байгууллагын үнэлгээтэй ойролцоо үр дүн гарах байх гэсэн хүлээлттэй байна.

■ **Банкны салбарын бүтцийн өөрчлөлт гэж юу вэ. Яагаад, ямар зорилгоор банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийдэг юм бол?**

Эрүүл банкны систем нь эдийн засгийн тогтвортой өсөлтийн чухал тулгуур хүчин зүйлсийн нэг болдог. Банкны үйл ажиллагаа доголдсоноор санхүүгийн зуучлал саарч эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлдөг. Иймд банкны үйл ажиллагааг хянан зохицуулагч байгууллагын үндсэн үүрэг болох хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн

“Эрүүл банкны
систем нь
эдийн засгийн
тогтвортой
өсөлтийн чухал
тулгуур хүчин
зүйлсийн нэг
болдог.”



ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ Н.БАТСАЙХАН

АЖЛЫН ТУРШЛАГА

Одоо: Монголбанк, Хяналт, шалгалтын газар, Захирал
2006-2016: Монголбанк, Эрсдэлийн удирдлагын алба, Захирал
2006: Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Ахлах эдийн засагч
2000-2004: Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Эдийн засагч
1999-2000: Монголбанк, Статистик, судалгааны газар, Эдийн засагч

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

2006: Олон улсын хөгжлийн магистр, Олон Улсын Их Сургууль, Япон улс
1998: МУИС, Бизнесийн удирдлагын магистр
1996: МУИС, Эдийн засгийн бакалавр

системийн найдвартай, тогтвортой байдлыг хадгалах зорилготой ажилладаг. Товчхондоо, бүтцийн өөрчлөлт гэдэг нь аливаа нэг банкны үйл ажиллагаа доголдож цаашид үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон эсхүл ойрын хугацаанд боломжгүй болох нөхцөлд зохицуулагч байгууллагаас банкны үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, удирдлага гэх мэт чиглэлд тусгайлсан цогц арга хэмжээг авч буй үйл ажиллагаа юм. Манай улсын хувьд эдгээр арга хэмжээ нь Банкны тухай хуулиар зохицуулагддаг.

■ Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрхэн хийдэг вэ?

-Юуны өмнө улс орон бүр өөрийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн салбарын онцлог болон урт хугацааны санхүүгийн хөгжлийн стратегийн бодлого зэргийг үндэслэн банкны салбарт хийх бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөтэй байх шаардлагыг олон улсын холбогдох байгууллагууд тавьдаг. Эдгээр төлөвлөгөөны үндсэн зарчим, зорилго нь санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй, санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэгдсэн байдаг.

“Монголбанкны хувьд активын чанарын үнэлгээ нь хөндлөнгийн байгууллагын үнэлгээтэй ойролцоо үр дүн гарах байх гэсэн хүлээлттэй байна.”

Олон улсад банкны бүтцийн өөрчлөлтийг хэд хэдэн тогтсон, стандарт болсон арга хэрэгслийг ашиглан хийдэг. Тухайлбал, банкны зарим хөрөнгө, эх үүсвэрийг гуравдагч банкинд шилжүүлэх, богино хугацаанд гүүр банк байгуулан улмаар хувьчлах эсхүл бусад банктай нэгтгэх, өмнөх хувьцаа эзэмшигчдэд банкны алдагдлыг ногдуулан өөрийн хөрөнгийг дахин хөрөнгөжүүлэх гэх мэт арга хэрэгсэл түгээмэл ашиглагддаг. Сүүлийн хэдэн жил их яригдаж байгаа, ялангуяа, Европын Холбооны орнуудад бүтцийн өөрчлөлтийн удирдамжид тусгагдсан банкинд хөрөнгө байршуулсан хөрөнгө оруулагчдыг хувьцаа эзэмшигч болгох зохицуулалт буюу “bail in” гэх аргачлал нь бүтцийн өөрчлөлтийн хүрээнд төсвийн буюу татвар төлөгчдийн хөрөнгийг бага зарцуулах аргачлал гэж үздэг. Дээрх аргачлалуудаас нийт эдийн засаг, төсөвт хамгийн бага хохирол, сөрөг нөлөө үзүүлэх аргачлалыг маш нарийн тооцоо судалгаатай хийн сонгож хэрэгжүүлдэг.

■ Банкны бүтцийн өөрчлөлтийг хэзээ хэрэгжүүлдэг вэ?

-Дээр хэлсний дагуу зохицуулагч байгууллага нь банкны үйл ажиллагааг хэвийн, тогтвортой үргэлжлүүлэхийн тулд банкинд бүтцийн өөрчлөлт хийдэг. Банкны үйл ажиллагаа иргэд, аж ахуйн нэгж

компани, хөрөнгө оруулагчдийн итгэлцэл дээр оршин тогтнодог тул банкны үйл ажиллагаа доголдохоос өмнө аль болох хурдан цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд нөхцөл байдал хүндрэхээс өмнө, бүтцийн өөрчлөлтийн зардлыг харьцангуй бага байх үед шуурхай арга хэмжээ авах нь чухал. Гэвч өнөөгийн манай хууль тогтоомжоор хянан зохицуулагч байгууллага нь тодорхой зөрчил үүссэн, асуудал гарсан нөхцөлд л арга хэмжээ авах эрхтэй байдаг. Энэ нь зарим тохиодолд хэт оройтсон арга хэмжээ байхыг үгүйсгэх аргагүй тул тухайн банкны үйл ажиллагаа нь тодорхой эсрдэлийн түвшинд хүрч, цаашид тус асуудал нь хүндрэх хандлагатай байх тохиолдолд тус үйл явцыг засч залруулах, эрсдэл үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хуулийн зохицуулалт дутмаг байна. Ийм ч учраас бид банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгохоор ажиллаж байна.


■ Банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн талаар авах арга хэмжээний талаар та тодорхой мэдээлэл өгнө үү?

-ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк нь “Банкны тухай хууль”, “Хадгаламжийн даатгалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн. Гэхдээ эдгээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил нь үүнээс өмнө “Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны ерөнхий хөтөлбөр” дэх Банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрт тусгагдсан байгаа юм. Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулж ОУВС-тай зөвшилцөн эдгээр хууль эрх зүйн шинэчлэлийг хөтөлбөрт хамруулж хийхээр төлөвлөөд байна. Эдгээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулан, мөрдүүлснээр Төв банкнаас хэрэгжүүлдэг банкны хяналт шалгалт нь олон улсын зарчим, шилдэг туршлагад илүү нийцтэй болно гэж үзэж байна. Түүнчлэн хадгаламжийн даатгалын тогтолцооны системийг илүү боловсронгуй болгосноор банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийг хамгаалсан тогтолцоо улам бэхжих болно. Дээрх хуулиудыг УИХ-ын намрын чуулганаар өргөн барихаар ажлаа эхлүүлээд байна.

Ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: Л.Энхдэлгэр (ОНБМТ-ийн мэргэжилтэн)

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ.ДОЛЛАРААР, 11/V ӨДРИЙН БАЙДЛААР)



УУЛ
УУРХАЙН
ТҮҮХИЙ
ЭДИЙН ЗАХ
ЗЭЭЛ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ ХЭЛТЭС



Эхний эгнээ: Зүүн гараас ахлах хянан шалгагч С.Батмөнх, хэлтсийн захирал Ч.Жамьянсүрэн, хянан шалгагч Д.Жавзанпагма.

Арын эгнээ: Зүүн гараас нягтлан бодогч Т.Цэмүүлэн, хянан шалгагч Ж.Баасансүрэн, нярав Н.Нарантуяа, ахлах нягтлан бодогч Ч.Мөнхтуул, жолооч Т.Ууганбаяр, тоологч Б.Мөнхбаяр

1. Нэгж байгуулагдсан

- БНМАУ-ын СнЗ-ийн 1961 оны 455 дугаар тогтоолоор Улсын банкны Дархан хот дахь хэлтсийг байгуулах шийдвэр гарсан бөгөөд 1962 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 1991 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 40/142 дугаар тушаалаар Монголбанкны салбар болгон өөрчилсөн.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 193 дугаар тушаалаар Сэлэнгэ аймаг дахь Монголбанкны салбарыг нэгтгэсэн.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А-19 дугаар тушаалаар Монголбанкны хэлтэс болгон өөрчилсөн байна.

2.Нэгжийн зорилго

Монголбанкны хэлтсийн зорилт нь орон нутагт Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоо, бэлэн мөнгөний эмиссийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэхэд оршино.

3.Нэгжийн нэр өөрчлөгдсөн

УБЕХ-ны Дархан хотын Банкны хэлтэс	1962-1978
УБЕХ-ны Дархан хотын Банкны контор	1978-1991
Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	1991-2013
Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс	2013 оноос

4. Нэгжийн удирдлага өөрчлөгдсөн: /1991 оноос/

№	МБЕ-ын шийдвэр огноо, дугаар		Албан тушаалтны нэр	Томилогдсон албан тушаал
1	1991.02.01	40/142	Ч.Намгансүрэн	Салбарын захирал
2	2007.03.29	147	Ж.Чинбат	Салбарын захирал
3	2013.01.25	Б49	А.Давааням	Хэлтсийн захирал
4	2014.04.08	Б167	Д.Дарханбаяр	Хэлтсийн захирал
5	2016.08.11	Б463	Ч.Жамъянсүрэн	Хэлтсийн захирлын үүрэг гүйцэтгэгч

5. Тухайн нэгжийн бүтэц өөрчлөгдсөн: /1991 оноос/

№	МБЕ-ын шийдвэрийн огноо, дугаар		Нэгжийн нэр	Тайлбар
1	1991.02.01	40/142	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	Банкны конторын нэрийг Монголбанкны салбар болгон өөрчилж, бүтэц, орон тоог шинэ тоотой батлав
2	2004.04.07	193	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	Сэлэнгэ аймаг дахь Монголбанкны салбарыг татан буулгаж, тус салбартай нэгтгэж, 10 орон тоотой батлав.
3	2007.03.29	147	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	Хянан шалгагчийн орон тоог 1-ээр нэмэгдүүлэв.
4	2008.06.05	244	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	Хянан шалгагчийн орон тоог 1-ээр нэмэгдүүлэв.
5	2013.01.25	А-18	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар	Салбарыг татан буулгав
6	2013.01.25	А-19	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс	Хэлтсийг шинээр байгуулж, бүтэц орон тоог шинэчлэн батлав.
7	2013.07.16	Б-132	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс	Ахлах хянан шалгагчийн орон тоог 1-ээр нэмэгдүүлэв.
8	2015.06.05	А-92	Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс	Захирлын орлогч болон ахлах хянан шалгагчийн орон тоог 2-оор хасч, хянан шалгагчийн орон тоог 2-оор нэмэгдүүлэв. байна

Хэлтсийн товч түүх: /Үүнд: Бүтэц зохион байгуулалт, үүрэг зорилго, түүнд гарсан томоохон өөрчлөлтүүд, гавъяа шагнал, ололт амжилт, түүхэн замнал/

БНМАУ-ын СнЗ-ийн 1961 оны 455 дугаар тогтоолоор Улсын банкны Дархан хот дахь хэлтсийг байгуулах шийдвэр гарсан бөгөөд 1962 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Дархан хотод банкны хэлтэс анх байгуулагдахад даргаар нь Жагваралын Жанлав, ерөнхий нягтлан бодогч Бэлчингийн Чингис, байцаагч Цэвэгдоржийн Дашдорж нарын зэрэг 7 хүний орон тоотой ажиллаж эхэлсэн байна.

Тус банкны хэлтэс Сэлэнгэ аймгийн Банкны хэлтэст харъяалагдаж байсан, энэ үед найрамдлын Дархан хот өдөр ирэх тутам өргөжин тэлэхийн хирээр банкны бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоогоор үйлчлүүлэх хүрээ ихсэж,

банкны үйлчилгээ өргөжин, улмаар гадаад, дотоодын банкуудтай харилцах шаардлага эрс нэмэгдсэн учир Улсын Банкны Ерөнхий хорооны даргын 1962 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 3/255 дугаар тушаалаар тус хотын Банкны хэлтсийг бие даалган ажиллуулжээ. Улмаар СнЗ-ийн 1978 оны 228 тоот тогтоолоор аймаг, хотын Банкны хэлтсийг контор болгон өөрчлөн, эрх үүргийг нь өргөтгөсөн юм.

Дархан хотын банкны конторт дарга, ерөнхий нягтлан бодогч буюу Бүртгэл гүйлгээний хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлтэс буюу конторын орлогч дарга, Зээл, мөнгөн эргэлтийн хэлтэс, Захиргаа аж ахуй, боловсон хүчин, хяналт шалгалтын байцаагчид болон туслах, үйлчлэх ажилчид зэрэг 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Үүнээс гадна тус конторын харьяанд Хөтөл, Шарын голын банкны хэлтэс ажиллаж, тэдгээрийн харьяа 10

гаруй тооцооны касст 110 орчим ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байжээ.

1990-ээд он гэхэд контор 545 байгууллагатай 11.2 тэрбум төгрөгийн гүйлгээг хийж, 20700 гаруй хадгаламж эзэмшигчдийн 22.8 сая төгрөгийн хадгаламжтай, 15.7 сая төгрөгийн ашигтай ажилладаг, улс ардын аж ахуйн томоохон салбарын нэг байжээ.

Банкны хэлтэс, конторын дарга нар:

- | | |
|--------------------------|--------------|
| 1. Жагваралын Жанлав | 1961-1965 он |
| 2. Сангидоржийн Лундаа | 1965-1968 он |
| 3. Надмидын Долгорсүрэн | 1968-1971 он |
| 4. Жавын Ламжав | 1971-1978 он |
| 5. Энэбишийн Сандагдорж | 1978-1981 он |
| 6. Жавын Ламжав | 1981-1985 он |
| 7. Чагдагийн Намгансүрэн | 1985-1991 он |

Монголбанкны салбарын захирал нар:

- | | |
|--------------------------|--------------|
| 1. Чагдагийн Намгансүрэн | 1991-2007 он |
| 2. Жамъяны Чинбат | 2007-2013 он |

Монголбанкны хэлтсийн захирал нар:

- | | |
|------------------------------|--------------|
| 1. Алтангэрэлийн Давааням | 2013-2014 он |
| 2. Доржготовын Дарханбаяр | 2014-2016 он |
| 3. Чойжилдоржийн Жамъянсүрэн | 2016 оноос |

1990-ээд оноос Монгол оронд нийгэм, эдийн засгийн гүнзгий өөрчлөлт орсонтой холбогдож Монгол улсын банкны хууль шинээр батлагдан гарав. Энэ хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд “Монгол улс дахь банкны тогтолцоо нь Монгол улсын Төв банк, арилжааны банкуудаас бүрдэнэ” гэж заасан. Иймд Улсын банкны хуучин бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, улмаар Дархан хот дахь банкны контороос арилжааны олон банкууд салбарлан байгуулагдав.

Дархан хот дахь банкны конторын суурь голомт болох Дархан-Уул аймаг дахь Монголбанкны салбар нь Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр 1991 оны 02 дугаар сараас эхлэн шинэ бүтэц, зохион байгуулалтанд орж ажиллав. Тухайн үед захирал, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч, оператор нягтлан бодогч, ахлах нярав, архив бичиг хэрэг гэсэн 6 орон тоотой ажиллаж эхэлжээ.

Бүс нутгийн харилцан тэгш бүс хөгжлийн байдлыг харгалзан УИХ-аас “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” хөгжлийн хүрээнд 2004 оны 4 дүгээр сард Монголбанк орон нутаг дахь зарим салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Сэлэнгэ, Дархан-Уул аймаг дахь салбаруудыг нэгтгэв.

Салбар/хуучин нэрээр/-ыг түшиглэн 2005 онд Монголбанкны Төлбөр тооцооны Нөөц төвийг байгуулав. Энэхүү Нөөц төвийн үйл ажиллагаа улам өргөжин тэлж Бага дүнтэй гүйлгээ болон картын систем, Банк сүлжээ буюу RTGS, Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн Nucleus системийн мэдээллийг архивлан хадгалдаг болов.

Эдийн засаг тэлж, банкны үйл ажиллагаа өргөжин санхүүгийн зуучлал нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголбанк бүтцийн өөрчлөлт хийж 2013 оны 01 дүгээр сараас эхлэн салбарын статусыг өргөтгөн хэлтсийн зохион байгуулалтанд шилжүүлэн оров.

Өдгөө тус хэлтэс 12 орон тоотойгоор Дархан-Сэлэнгийн бүс нутагт төрийн мөнгөний бодлогыг сурталчлах, арилжааны банкны нэгжүүдэд хяналт шалгалт хийх, тэдгээрийг бэлэн мөнгөөр хангах, мөнгөн тэмдэгт гүйлгээнээс татах ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Хэлтэст нийт 29 ахмад настан бүртгэлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН АЛБАН ЁСНЫ АНХНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

“Цагаан мөнгөн баталгаа бүхий мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах нь зүйтэй” хэмээн 1924 оны 8 дугаар сард хуралдсан МАН-ын III их хурлаар онцлон заажээ. Улмаар Монгол Улсын анхдугаар их хурлын тогтоолд гадаадын мөнгө хэрэглэх нь улс орны эдийн засагт ихээхэн хор хохиролтой болохыг тэмдэглээд үндэсний мөнгөн тэмдэгт бий болгох нь чухал гэж заасан байна. Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 1925 оны 2 дугаар сарын 22-ны өдөр “Мөнгөний шинэчлэлт явуулах” тухай тогтоол гаргаж, Монголын үндэсний мөнгөний нэгжийг “Төгрөг” гэж нэрлэсэн байна. Энэ шийдвэрийн дагуу Монголбанк 1925 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 200100 төгрөгийг анх гүйлгээнд гаргав.

Улсын анхны албан ёсны мөнгөн тэмдэгт 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр гарч байв. Тухайн үед мөнгөн тэмдэгтийн бүрэн баталгаа болж 25-аас доошгүй хувь нь үнэт металлаар, 75 хувь нь түргэн борлогдох бараа материалаар баталгаажуулагдаж байжээ.

Төгрөгийг анх гүйлгээнд гаргахдаа ажилчдын цалингаар дамжуулан гаргаж улмаар улсын хэмжээний бүх албан газруудын төсөвт зардлуудыг төгрөгөөр тооцох болжээ. Төгрөг гүйлгээнд гарангуут гадаадын мөнгөн тэмдэгтүүдийн ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан ч зах зээлд эзлэх жин багатай валютуудыг гүйлгээнээс түрүүлж татах ажлыг зохион байгуулж эхлүүлсэн нь амжилттай хэрэгжих үндэс болсон байна.

Ингээд 1927 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бүх төрлийн мөнгөн гүйлгээ, тооцоог зөвхөн “төгрөг”-өөр гүйцэтгэх болж худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлэх, зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг тодорхой хэмжээгээр зохицуулахад нөлөөлж, ардын аж ахуйтанд зээл олгох арга хэмжээг авч эхэлжээ.

Тиймээс 1925 оны мөнгөн тэмдэгтийг БНМАУ-ын мөнгөн тэмдэгтийн түүхэн үед хамаарагдах болохыг зоос цуглуулагчид үечилсэн байдаг. Анхны мөнгөн төгрөгийг 1966 онд гүйлгээнээс албан ёсоор халсан боловч түүнээс өмнө 1940-өөд онд гүйлгээнээс гарсан байжээ.



1925 оны нэг төгрөгийн дэвсгэрт



1925 оны хоёр төгрөгийн дэвсгэрт



1925 оны хорин таван төгрөгийн дэвсгэрт



1925 оны таван төгрөгийн дэвсгэрт



1925 оны тавин төгрөгийн дэвсгэрт



1925 оны арван төгрөгийн дэвсгэрт



1925 оны зуун төгрөгийн дэвсгэрт

Ашигласан материал: "Монгол улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж бэхэжсэний 90 жилийн түүхт ойд зориулав" Монголын зоос сонирхогчдын холбооны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн

"Монгол Улсын зоос, мөнгөн тэмдэгт" Ч.Энхбат, Б.Нямаа, Ц.Батсайхан

Бэлтгэсэн: Д.Ариунаа (ОНБМТ-ийн ахлах мэргэжилтэн)

ТӨГРӨГИЙН НЭРЛЭСЭН ҮЙЛЧИЛЖ БУЙ ХАНШ (NEER) ГЭЖ ЮУ ВЭ?

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) гэдэг нь Монгол төгрөгийн үнэ бусад гадаад худалдааны түнш 22 орны валютын сагсны эсрэг хэрхэн өөрчлөгдөж буйг харуулах үзүүлэлт юм.

- Гадаад валютын сагсны жин нь тухайн валютаар гүйлгээ хийдэг улс орнуудын Монгол улстай хийж буй гадаад худалдааны жингээр тооцдог.
- Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш буурах буюу суларснаар Монгол улсын зарж буй бараа бүтээгдэхүүний үнэ бусад орнуудтай харьцуулахад хямдарч Монголын экспортын бүтээгдэхүүний үнээр өрсөлдөх чадвар сайжрах боломжийг олгодог.
- Харин төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш суларсан ч зарим тохиолдолд тухайн улсын бараа, бүтээгдэхүүний үнийн түвшин өссөн тохиолдолд

экспортын орлого мөнгөн дүнгээрээ өссөнтэй ижил хувиар тухайн мөнгөөр худалдан авах барааны хэмжээ өсөхгүй байх тохиолдол бий.

ХЯЛБАР ЖИШЭЭ:

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 5%-иар суларсан нь Монгол улсад үйлдвэрлэсэн 1000₮-ийн үнэтэй дэвтрийн үнэ гадаад валютаар илэрхийлбэл 5%-иар хямд болсныг илэрхийлнэ. Харин бодит үйлчилж буй ханш 3%-иар суларсан гэж үзвэл уг дэвтрийн үнийг дэвтэр бүтэх өртөгтэй харьцуулахад 3%-иар хямдарсныг илэрхийлж байна.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН ХУРЛААС... (2017.05.26)

■ ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжсэнээр валютын нөөц нэмэгдэнэ гэж байна. Тэгвэл яг одоогоор валютын нөөц хэд байгаа вэ?

Зах зээлийн газрын захирал Б.Батдаваа:

Монгол Улсын гадаад валютын нөөц хамгийн сүүлийн байдлаар 1.2 тэрбум ам.доллартай тэнцэж байгаа. Энэ нь импортын 3.2 сарын хэрэгцээг хангах түвшинд байгаа үзүүлэлт. ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд нөөц маань аажмаар нэмэгдэж, оны эцэс гэхэд 1.6 тэрбум ам.доллар, 2020 он гэхэд 4 тэрбум ам.долларт хүрч, импортын 6.7 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч өснө гэх таамаглалыг бид хийсэн байгаа.

■ Ипотекийн 8 хувийн хөтөлбөрийн санхүүжилт хэвийн үргэлжилж байгаа юу. Иргэд ипотекийн зээлд хамрагдаж чадахгүй байна гэх гомдол өнөө хэр байсаар байна. Санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжийг Монголбанк судалж байгаа юу?

МБГ-ын Бодлогын хэрэгжилт, зээлийн хэлтсийн захирал Д.Баянзул:

Ипотекийн 8 хувийн зээл 2017 онд Монголбанкны эзэмшиж байгаа Ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн болон купоны төлбөрийн эргэн төлөлтөөр санхүүжигдэж байгаа. Энэ нь сард дунджаар 25 орчим тэрбум төгрөг. ОУВС-гийн хөтөлбөртэй холбоотойгоор



ЗГ энэ хөтөлбөр дээр давхар орж ирж байгаа. Дөрөвдүгээр сард батлагдсан төсвийн тодотголоор 111 тэрбум төгрөгийг улсын төсөвт суулгасан. Энэ онд Засгийн газар, Монголбанк хөтөлбөрийг хамтран санхүүжүүлнэ. Ирэх жилээс хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлнэ. Үүний бэлтгэл ажлыг Монголбанк хийж ажиллаж байна.

■ Цаашдаа санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой юу?

Энэ жилийн хувьд одоогийн зарчмаараа сард 25 тэрбум төгрөгөөр санхүүжүүлээд явна. Ирэх жилийн тухайд санхүүжилтийн ямар зарчмаар, хэрхэн явах вэ гэдэг дээр Засгийн газартай хамтран ажиллаж байна. Мөн Дэлхийн банкны зөвлөлтэй хамтраад, яг ямар хувилбараар цаашид явах вэ гэдгийг судалж байна.

■ Оны эхний улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 4 хувь буюу хүлээлтээс давж гарлаа. Энэ нь

улирлын шалтгаантай байв уу, эсвэл Монголын эдийн засаг цаашдаа идэвхжиж, өсөлт нэмэгдэх хандлагатай байгаагийн илрэл үү. Төв банкны хувьд хэрхэн харж байна вэ?

Зах зээлийн газрын захирал Б.Батдаваа:

Эдийн засгийн өсөлтийн хувьд 2016 оны эцэст ОУВС-гаас хүлээж байсан төсөөллөөс илүү өндөр буюу 1 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Учир нь дөрөвдүгээр улиралд уул уурхайн салбарын өсөлт хүлээгдэж байснаас өндөр гарсан. Энэ нь уул уурхайн бус салбартаа дамжиж нөлөөлөх замаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байгаа. 2017 онд эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнө нь -2.1 хувь гэж байсан. Уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор энэ төсөөллийг шинэчилж, -0.2 хувь гэж таамаглаж байгаа. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтийг энэ онд бага зэрэг агшилттай буюу 0 орчим хувь байна гэж харж байгаа. Цаашдаа томоохон мега төслүүд амжилттай хэрэгжсэн тохиолдолд эдийн засгийн өсөлтийн төлөв өөрчлөгдөх боломжтой.

■ УИХ-аар нийгэм, эдийн засгийг 2018-2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэлэлцэж эхэллээ. Энэ нь ОУВС-гийн хөтөлбөртэй уялдаж байгаа юу. Монголбанк энэ төсөл дээр саналаа өгсөн үү?

Зах зээлийн газрын захирал Б.Батдаваа:

УИХ-аар хэлэлцэгдэж байгаа нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хувьд ОУВС-гийн хөтөлбөртэй уялдаатай байгаа. Тийм учраас томоохон өөрчлөлт гарахгүй болов уу.

■ УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны шалгалтын дүн гарсан. Монголбанкны одоогийн удирдлагууд энэ дүгнэлттэй танилцсан уу, хэзээ хариу өгөх вэ?

Монголбанкны Хэвлэлийн төлөөлөгч Д.Оргил:

Ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт албан ёсоор Монголбанкинд ирээгүй байгаа. Албан ёсоор ирсний дараа энэ талаар тайлбар, мэдээлэл өгөх боломжтой.



ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТ: ЯАГААД ИНФЛЯЦИ ВЭ?

Б.Түмэнцэнгэл
(Монголбанкны ОНБМТ-ийн
ахлах эдийн засагч)

Дэлхийн ихэнх улс орнууд эдийн засаг нь тогтвортой байхад тус болно гэж үзээд төв банк гэдэг институцийг байгуулдаг. Ингэхдээ гүйцэтгэх нь үүрэг ролийг нь төв банкны тухай хуулиар тусгайлан зааж өгдөг жишиг тогтжээ. Өнөө үед хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнуудын хувьд төв банк үнийн тогтвортой байдлыг урт хугацаанд хадгалах явдлыг үндсэн зорилтоо болгох нь түгээмэл байна. Тэгвэл эдийн засагт хэдийгээр ажил эрхлэлт, ядуурал, ДНБ-ийн өсөлт, өрсөлдөх чадвар г.м. олон чухал асуудал бий ч тэр дундаас инфляцийг төв банкинд ийнхүү хариуцуулдаг нь ямар учиртай вэ?

Үнийн тогтвортой байдлын ач холбогдол

Инфляци нь эдийн засгийн өсөлт, ядуурал г.м. асуудлууд шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед “мартагддаг” гэж хэлж болохоор үзүүлэлт. Харин үнэ тогтвортой байхаа больсон цагт л бид ямар чухал зүйл болохыг нь гэнэт ухаарах тохиолдол олон.

Тухайлбал, 90-ээд оны эхээр Монголд инфляци 300% давж, жилийн дотор үнэ 3 дахин өсөхөд иргэдийн хэрэглээ, худалдан авах чадварт хэрхэн дарамт учирч байсныг олон хүн нүдээрээ үзсэн. Эсвэл Японы сүүлийн 30 жилийн түүхээс бараа бүтээгдэхүүний үнэ олон жил дараалан буурч дефляци үргэлжлэх үед компаниуд хөрөнгө оруулалтаа хэрхэн танаж, ажиллах хүчээ цомхотгож байсныг харж болно. Латин Америкийн зарим оронд 80-аад онд мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнэгүй цаас болгон хувиргах гипер инфляци үүсэхэд банк санхүүгийн систем нь хямарч байв.

Тэгэхээр бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлт нь худалдан авалт хийж буй, хадгаламж эсвэл бизнесийн хөрөнгө оруулалт хийх гэсэн хэн бүхэнд шууд нөлөөтэй учраас үнэ тогтвортой байх нь нийгэмд ашигтай зүйл. Инфляци тогтвортой байх нь эдийн засаг бүхэлдээ тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс нь болох учраас энэ чухал асуудлыг хариуцсан эзэн заавал байх ёстой.

Инфляцийг яагаад заавал төв банк хариуцах ёстой гэж?

Төв банкууд мөнгөн дэвсгэртийн үнэ цэнийг хамгаалах, засгийн газрын төлбөр тооцоог гүйцэтгэх, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зэрэг үүргүүдийг биелүүлж ирсэн ч инфляцийг “хариуцдаг эзэн” нь болсон нь харьцангуй саяхан тогтсон жишиг юм.

Түүх сөхвөл, XVII зуунд байгуулагдаж байсан анхны төв банкуудтай харьцуулахад энэхүү институци өнөөдөр танигдахгүй болтлоо хувьсан өөрчлөгдсөн гэхэд болно. Орчин үеийн төв банкны анхны загвар гэгддэг Английн төв банк гэхэд 1600-аад оны сүүл үед улсдаа хамгийн том арилжааны банк байв. Үнийн тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдал г.м. одоогийн төв банкуудын үүрэг харин тэр үед байсангүй. Хараат бус байдлыг нь хуулиар баталгаажуулж, үндсэн зорилт нь үнийн түвшнийг тогтвортой байлгахад чиглэгдсэн төв банк дэлхийн II дайны дараах Германд анх бий болсон байдаг. Үүний гол шалтгаан нь I дайны өр төлбөрөө мөнгө хэвлэж санхүүжүүлсний улмаас гипер инфляцитай тулгарч, эдийн засгийн асуудал нь

фашизм, цаашлаад дахин нэг дэлхийн дайн руу түлхсэн түүхээс авсан сургамжтай холбоотой байв.

Ер нь 1990-ээд он хүртэл ихэнх улс орнуудад төв банкууд засгийн газрынхаа харъяанд байсан бөгөөд 1980-аад он гэхэд ердөө 20 орчим төв банк л засгийн газраасаа хараат бус болсон байдаг. Татварын мөнгөөр бүрдэх хязгаарлагдмал төсвөөр үйл ажиллагаа явуулдаг засгийн газруудын хувьд ийнхүү мөнгө хэвлэх эрхтэй байх нь мэдээж таатай зүйл. Гэхдээ сонгогчдынхоо өмнө улстөрийн амлалтаа биелүүлэхийн тулд ажилладаг институци өөрөө мөнгө хэвлэх эрхтэй байх нь аюултай байв. Энэ нь мөнгөний бодлогод улстөр нөлөөлж, улмаар үнийн тогтвортой байдлаа алдсан улс орнуудын алдаануудаас хялбархан ойлгогджээ. Иймд үнийн тогтвортой байдлыг гагцхүү мөнгө хэвлэх эрхтэй тэр байгууллагад өөрт нь хариуцуулж, тэрхүү байгууллагын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж өгөх нь чухал болжээ.

Төв банк яагаад зөвхөн инфляцийг хариуцах ёстой гэж?

Нэг талаар, олон асуудалд зэрэг анхаарлаа хандуулах нь эсрэгээрээ аль ч зорилгоо амжилттай биелүүлж чадахгүйд хүргэнэ гэдэг энгийн логик төв банкны хувьд ч үйлчилдэг. Нэгэнт л бүх асуудлыг шийддэг ид шидтэн биш учраас төв банк тодорхой нэг асуудлыг л хариуцсан шиг хариуцах нь түүнийгээ амжилттай биелүүлэх үндэс нь юм. Үүнийг практик дээр баталсан судалгаанууд ч хангалттай олон байх бөгөөд, олон зорилт урдаа тавьсан төв банкууд үндсэн гол зорилтдоо ч хүрч чадахгүй байх тохиолдол түгээмэл байдаг.

Харин нөгөө талаар, макро эдийн засгийн маш олон чухал асуудлаас чиг үүргийнхээ дагуу төв банк шууд оролцоод, урт хугацааны шийдэл санал болгох зүйл бараг үгүй. Жишээ нь, аль нэг салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлэх, хүн амыг өсгөх, мэдлэг ур чадварыг нь ахиулах тал дээр мөнгөний бодлого тусалж чадахгүй учир эдийн засгийн өсөлтөд шууд оруулах хувь нэмэр нь хязгаарлагдмал. Мэдээж эдийн засагт эргэлдэж буй мөнгийг ихэсгэх замаар түр хугацаанд эдийн засгийг идэвхжүүлж болох ч энэ нь үнийн хөөсрөлийг үүсгэж ирээдүйн хямралын шалтгаан болох эрсдэлтэй тул

урт хугацаанд үргэлжлэх аргагүй гэдэг нь ойлгогдоно. Иймд төв банк “Үнийн тогтвортой байдлаар дамжуулж эдийн засагтаа хувь нэмэр оруулах уу”, эсвэл “Эдийн засгийн өсөлтийг давхар зорьсноор инфляцийг ч өдөөж, өсөлтийг ч үгүй хийх үү” гэдэг 2 сонголтын аль оновчтойг хувилбарыг сонгож буй хэрэг гэхэд болно.

Олон нийтийн хүлээлт ба төв банкны зорилтын биелэлт

Инфляцийг зорилтот түвшиндээ байлгахад нөлөөлдөг нэг гол хүчин зүйл нь зах зээл дээрх хүлээлт юм. Учир нь иргэд, аж ахуйн нэгжүүд г.м. зах зээлд оролцогчид юу гэж итгэхээс хамаараад тэдний хийх үйл хөдлөл тодорхойлогдож, энэ нь цаашлаад эдийн засагт юу болохыг шийддэг. Иймд төв банк хүлээлтийг хэрхэн оновчтой удирдах вэ гэдэг нь мөнгөний бодлогын гол асуудал болдог. Тэгэхээр зах зээлд оролцогчид төв банкнаас зөв зүйл хүлээж байна уу, төв банкны үндсэн зорилтыг ойлгож байна уу гэдгээс ихээхэн зүйл хамаарах юм.

Харин нийгмийн зүгээс төв банкны эдийн засагт бүхнийг чадагч ид шидтэн мэтээр төсөөлж, хэт өндөр хүлээлт тавин магадгүй хуулиар хориглосон зүйлсийг хүртэл шаардах нь олон асуудлын эхлэлийг тавьдаг. Жишээ нь, хүн бүрт л мөнгө хэрэгтэй ч төв банк бүгдэд хүрэлцэхээр мөнгийг хэвлээд тараавал мөнгөн тэмдэгт өөрөө үнэ цэнэгүй зүйл болж хувирна. Ийм гэнэн зүйлийг мэргэжлийн эдийн засагчдын багаас бүрдсэн институци арай ч хийхгүй гэж санагдах ч, бодит амьдрал дээр олон төв банк чухам энэ алдааг гаргасан тохиолдол цөөнгүй.

Тэгэхээр төв банк хүлээлтийг зөв удирдаж, инфляцийн зорилтоо биелүүлж чадах эсэх нь төв банкны зорилго зорилтыг, хэрэгжүүлж буй бодлогыг олон нийт ямар түвшинд ойлгож буйгаас ч ихээхэн хамааралтай юм. Иймд, төв банкууд үнийн тогтвортой байдлыг хангаж эдийн засагтаа хувь нэмрээ оруулахын тулд бодлогоо зөв тайлбарлаж ойлгуулах, үүнийгээ үр дүнтэй байлгахын тулд олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхийг зорьдог болжээ. Түүнчлэн, нийгмийн хүлээлт улстөрийн дарамт болж төв банкин дээр ирэх үед хараат бус байдлыг нь хангах хуулийн дархлаатай болохыг ч чухалчилж байна.



Чех

Үнийн тогтвортой
байдал



Польш

Үнийн тогтвортой
байдал



Өмнөд Солонгос

Үнийн тогтвортой
байдал



Бразил

Дотоод валютын
тогтвортой байдал



Хятад

Дотоод валютын
тогтвортой байдал



Энэтхэг

Мөнгөний
нийлүүлэлтийн
тогтвортой байдал



Чили

Үндэсний валютын
тогтвортой байдал



Индонези

Рупиагийн тогтвортой
байдлыг хадгалах

**ДЭЛХИЙН ТӨВ
БАНКУУДЫН
ЗОРИЛТУУД**



Америк

Бүрэн ажил эрхлэлт,
үнийн тогтвортой
байдал



Европын төв банк

Үнийн тогтвортой
байдал



Норвеги

Үнийн тогтвортой
байдал



Япон

Үнийн тогтвортой
байдал



Австрали

Үнийн тогтвортой
байдал



Англи

Үнийн тогтвортой
байдал



Шинэ Зеланд

Үнийн тогтвортой
байдал



Швед

Үнийн тогтвортой байдлыг
хангах ба найдвартай,
аюулгүй төлбөрийн
системийг хөгжүүлэх

ДЭЛХИЙН ТӨВ БАНКУУДЫН ЗОРИЛТУУД



МОНГОЛ ТӨГРӨГ

Монгол Улсын Үндсэн хуулинд есөн хөлт цагаан туг, сүлд, далбаа, дуулал, тамга зэрэг таван зүйлийг Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг мөн хэмээгээд Төрийн бэлгэдэл гэж нэрлэсэн байдаг. Харин манай улсын эдийн засгийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг нь яахын аргагүй үндэсний мөнгөн тэмдэгт маань болох төгрөг билээ. Төгрөгийг бид өдөр тутмын хэрэгцээгээ хангах зорилгоор хэрэглэж, гүйлгээнд эргэлдүүлж байдаг. Гэвч сүүлийн үед улсынхаа нэгэн бэлгэдэл болсон мөнгөн тэмдэгтэй зүй бусаар харьцах нь олширчээ. Миний бие өөрийн ажиглалт дээр тулгуурлан нийтлэг илэрч буй иргэдийн муу зуршлуудаас дурдъя.

Монгол хүмүүс эрт үеэс бөө мөргөл, шашин соёлоо шүтэж ирсэн шүтлэг ихтэй ард түмэн. Тиймдээ ч уул ус, газар тэнгэрээ дээдэлж, овоо тахилгадаа өргөл барьц өргөхийн сацуу алтан нарандаа цай идээнийхээ дээжийг, тэнгэр бурхандаа идээ будаа, хадаг яндар юугаан сүсэглэн өргөдөг сайхан уламжлалтай билээ. Гэвч шинэ эрин зуунтай золгоод уламжлалт ёс заншил маань солигдчихов уу гэлтэй өргөл барьцын хэлбэр өөрчлөгдөөд байх шиг. Уул толгодын оройд сүндэрлэх овоо тахилгын газарт идээ будаанаас илүүтэйгээр мөнгө төгрөг хэвтэх болжээ. Сүсэглэн мөргөсөн эзэндээ ээлтэй сайхан санагдаж, амьдралд нь аз жаргал ирэхийн ерөөлийг дуудсан л мөнгө байх. Гэвч арай өөр өнцгөөс харах юм бол эрхэмлэн дээдлэх учиртай

Монгол төгрөгөө хогийн саванд хаяж буйтай дүйцэхүйц үйлдэл билээ. Учир нь овооноос мөнгө түүж буяндаа бузар хийх сэтгэлтэй хүн ховор тул энд нэгэнт хаягдсан мөнгийг хэн ч хэзээ ч ахин хэрэглэхгүй. Нэгэнт л өргөө гээд зориглосон хэд гурван төгрөгөөрөө атга будаа худалдан аваад өргөвөл нэг талаасаа эдийн засагт ээлтэй, нөгөө талаас овооны эзэд болсон амьтдад хоол нь болж, жинхэнэ утгаараа сайн сайхны бэлгэдэл болох бус уу. Үнэхээр л мөнгөнөөс өөр өгчих зүйл олдохгүй бол хээрийн гурван чулуугаа сүсэглээд өргөж болно шүү дээ.

Зарим мөнгөн дэвсгэрт дээр утасны дугаар, хүний нэр, тэр бүү хэл хайрын захиагаа сийрүүлэн үлдээдэг нь төгрөгийг тэмдэглэлийн дэвтэртэй андуурахад хүргээд байна. Монгол төгрөгийг цаасаар үйлдвэрлэдэг нь үнэн, гэхдээ энгийн нэг бичгийн цааснаас илүү үнэлгээтэй байх болов уу. Манай улс дотооддоо мөнгөн дэвсгэрт үйлдвэрлэдэггүй бөгөөд маш өндөр технологи, нууцлалын дор харийн улсад хэвлүүлдэг билээ. Хэвлүүлэх ханш, зөөвөрлөх үнэ, ажилчдын хөлс гээд бодоод үзэхэд л асар их хөрөнгийг зарцуулж байгаа нь илт. Өөрөөр хэлбэл, нэг төгрөг маань өөрөөсөө давсан үнэлгээг өөртөө агуулдаг байна. Ийм их хөрөнгөөр бидний гар дээр ирж буй төгрөгийг цагаан цаастай зүйрлээд л байвал манай улсын эдийн засагт үргүй хохирол үүсээд л байх нь тодорхой.

Их олон хүний сэтгэлийг өвтгөж, хотын соёлын



үнэнг дэлгэсэн үйлдэл бол мөнгө урж, тасдах явдал байлаа. Нэг хэсэгтээ л кондуктор гэх хүнээс салж, бэлэн мөнгөний хайрцганд мөнгө тушаах аян Улаанбаатар хотын бүх чиглэлийн автобусанд өрнөсөн билээ. Соёлтой боловсон залуус их байсан ч гэсэн сайны хажуугаар саар гэгчээр өнөөдрөө л бодсон увайгүй авирлагчид бас мэр сэр ажиглагдсан юм. Автобусаар үйлчлүүлснийхээ төлбөрт өгч буй таван зуун төгрөгийг урж тасдаад хийх нь яг тэр үедээ ашигтай ажилласан мэт санагддаг байх. Гэхдээ дуслыг хураавал далай гэдэг шиг нэлээн хэдэн хүн нэг бус хэд хэдэн төгрөгийг ураад ирэх үед жинхэнэ эмгэнэл үүсэх нь дамжиггүй. Эзэн Чингис хаанаараа бахархан, цээжээ дэлддэг Монголчууд бид хөрөг зургийг нь хоёр хувааж хаях нь яалт ч үгүй эмгэнэл мөнөөсөө мөн. Өнөөх өндөр өртгөөр бүтээд байгаа мөнгө төгрөгөө ураад байх нь эцэстээ эдийн засаг, улс оронд маань хохиролтой гэдгийг та бид ойлгож авах нь зүйтэй.

Үндэсний эд зүйлдээ гамгүй нэгэн байхад хайрлаад халамжилдаг нэг нь ч бас байх юм. Өнгөрсөн жилийн зун миний бие оюутан солилцооны хөтөлбөрөөр Америкийн Нэгдсэн Улс гэх өндөр хөгжилтэй, эрс өөр соёлтой том айлаар айлчлаад ирсэн билээ. Хөгжингүй орны хүмүүс гэсэндээ арай л өөр түвшний соёл намайг угтсан юм. Алсын орныг зорьсон миний сонирхлыг татаж байсан зүйлсийн нэг бол Америкчуудын мөнгөтэй харьцах соёл байлаа. Мөнгөн дэвсгэрт бол

эх орных нь үнэт зүйл мөн гэдгийг мэддэг тэр хүмүүс долларыг нугалаж базах нь бараг үгүй. Худалдагчаар ажиллаж байх үедээ Монголд ажиглагддаг шиг уранхай ноорхой мөнгөн дэвсгэртэй цөөн удаа харьцсан нь үүний илрэл байх. Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэдгийн адил Америкчууд үр хүүхдүүддээ багаас нь мөнгөтэй зөв зохистой харьцах соёлыг заадаг заншилтай бололтой.

Төгрөгийн худалдан авах чадвараас хамааран хайрлаж халамжлах сэтгэл өөрчлөгддөг ч гэсэн хорин мянга ч бай арван төгрөг ч бай манай улсын баялаг шүү дээ. Эхдээ гологдсон хурга шиг Монголдоо адлагдаад буй мөнгөн дэвсгэртээ та бид л хайрлаж чадна. Монгол улсаараа бахархах бахархал, хайрлах сэтгэл танд байдаг бол эх орондоо хийх энгийн нэг тус тань үндэсний мөнгөн дэвсгэрттэйгээ зүй зохистой харьцах явдал юм. Монгол хүн та мөнгөний эл соёлыг өөртөө суулгаж, үр хүүхдэдээ сургаад явбал төгрөг мөнгөний үнэ цэнэ улам нэмэгдэж, эх орон маань танаар бахархах нь дамжиггүй.

*Монгол Улсын Их Сургуулийн оюутан
Э. Элбэгжаргал*



ӨРХИЙН ТӨСӨВ ЗОХИОХ АРГАЧЛАЛ


МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш, доктор Д.Оюунцэцэг

Өрхийн төсөв зохиохын тулд юуны өмнө тодорхой хугацааны туршид (хамгийн багадаа 3 сар) орлого, зардлаа тогтмол бүртгэж, дүгнэх хэрэгтэй. Ингэснээр хэрэгжихүйц бодит төсөв зохиох боломж бүрдэнэ. Төсөв нь орлого болон зарлага гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд орлого, зарлагыг өөрийн санхүүгийн зорилгод тохируулан ангилж, орлого, зардлын төрөл тус бүрээр төсвөө зохиох хэрэгтэй.

Өрхийн төсвийг зохиохдоо дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Санхүүгийн сахилга бат, хариуцлагатай байх;
- Өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг эрэлхийлж, ашиглах;
- Тэвчиж болох зардлыг хэмнэх, хасах;
- Өрхийн төсвөө нэг байлгаж, шийдвэрийг хамтдаа хэлэлцэж гаргах;
- Хадгаламжийн дансаа хоёр хүний нэртэй, мөн хоёр хүний гарын үсэгтэй байлгах;
- Аль болох зээлгүй байхыг эрмэлзэх гэх мэт.

Бүдүүвч 1. Өрхийн төсөв зохиох үе шат



1. Санхүүгийн зорилгоо тодорхойлох

Өрхийн санхүүгийн зорилго нь төлөвлөгөөний дагуу ирээдүйд хуримтлуулах, зарцуулах, хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний үндэс суурь болно. Иймээс өрхийн амьдралын нөхцөл байдалд тохирсон санхүүгийн зорилгоо тодорхойлох хэрэгтэй. Санхүүгийн зорилго нь:

- (1) Хэрэгжих боломжтой, бодит байх;
- (2) Нарийн тодорхой, цаг хугацаанд суурилсан байх;
- (3) Мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн байх;
- (4) Үйл ажиллагаанд чиглэсэн байх ёстой.

2. Орлогоо тооцох

Өрхийн төсвийн нийт орлого нь тухайн өрхийн гишүүдийн орлогын нийлбэрээс бүрдэнэ. Төсөв зохиохдоо тодорхой хугацаанд олох боломжтой орлогоо тооцох ёстой. Боломжит орлогын хэмжээг өмнөх хугацааны орлогын бүртгэлд үндэслэн тооцох нь илүү бодитой болдог. Бэлэг, шагнал зэрэг тодорхой бус орлогыг бодитоор хүлээн авах мөнгө гэж тооцох боломжгүй. Хэрэв орлого тогтмол биш, эсвэл улирлаас хамаарч өөр өөр байдаг бол орлогыг төлөвлөх хэцүү байж болно. Ийм нөхцөлд өмнөх хугацааны болон одоогийн төсөөлөлд суурилан орлогоо тооцох хэрэгтэй. Орлогоо бодитоор тооцох нь хэтрүүлж хэрэглэх болон бусад санхүүгийн хүндрэлээс зайлсхийхэд тусална.

3. Хуримтлал буюу аюулгүй байдлын нөөц үүсгэх

Ирээдүйн санхүүгийн зорилгодоо хүрэх, эрсдэлээс хамгаалахад хуримтлал чухал ач холбогдолтой. Иймээс хувь хүн, өрх бүр хуримтлал үүсгэж, түүнийгээ байнга өсгөн нэмэгдүүлж байх хэрэгтэй. Үүний тулд орлого олсон л бол түүнээсээ тодорхой хэсгийг нь хуримтлуул гэсэн зарчмыг баримтлах нь зүйтэй. Хүмүүсийн гаргадаг түгээмэл алдаа бол сарын эцэст мөнгө үлдвэл л хадгална гэх үзэл юм. Хадгалах мөнгө үлдэхгүй байвал яах вэ? Гэтэл хуримтлал, хадгаламж гэнэтийн болон урт хугацааны санхүүгийн аюулгүй байдлыг хангах хамгийн чухал зүйл байдаг.

Тиймээс өрхийн төсөв зохиохдоо санхүүгийн зөвлөхүүдийн өгдөг дараах зөвлөгөөг анхаарч, хэрэгжүүлэх нь хуримтлал үүсгэн, санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлэх энгийн, хялбар арга юм. Үүнд:

- Нийт орлогынхоо 5-10 хувийг хуримтлалд хуваарилах - Өрхийн төсөв зохиохдоо өрхийн нийт орлогоосоо тодорхой хувийг тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан хуримтлалдаа хуваарилаарай.
- Гэнэтийн хэрэгцээг хангах аюулгүй байдлын нөөц нь тухайн өрхийн 3-6 сарын амьжиргааны зардалтай тэнцэхүйц хэмжээнд байх. Гэхдээ хувь хүний амьдралын нөхцөл байдал, ажил эрхлэлтийн тогтвортой байдлаас хамаарч хэмжээ нь өөр өөр байж болно. Тухайлбал, тогтвортой орлого, найдвартай ажлын байртай хүнд 3 сарын зардалтай тэнцэхүйц хэмжээний аюулгүй байдлын нөөц хангалттай байхад тогтмол бус, улирлаас хамаарсан орлоготой хүн 6 сар болон түүнээс дээш хугацааны амьжиргааны зардалтай тэнцэхүйц нөөц бүрдүүлэх хэрэгтэй.

4. Зардлаа төсөвлөх

Амьдралын ялгаатай нөхцөл байдлаас хамаарч өрх бүрийн төсвийн хуваарилалт өөр өөр байдаг ч зардлыг төсөвлөх зарчим нь адил байна. Үүнд:

Өмнөх хугацааны зардлын бүртгэлд үндэслэн нийт зардлын хэдэн хувийг ямар зардал эзэлж байгааг тооцох хэрэгтэй. Мөн өмнөх саруудын зардалд шинжилгээ, дүгнэлт хийж, хэмнэж, тэвчиж болох зардлыг илрүүлэн


өрхийн төсөв зохиохдоо зардлаа бууруулна.

Зардлаа төсөвлөхдөө өрхийн санхүүгийн зорилгыг хэрэгжүүлэх, өрхийн гишүүдийн зайлшгүй хэрэгцээг аль болох бүрэн хангахуйцаар байхаар тооцно.

5. Төсвийн илүүдэл, дутагдлыг тооцож, шийдвэр гаргах

Өрхийн орлого, хуримтлал, зардлыг төлөвлөсний дараа нийт орлого, зарлагын зөрүүг тооцно. Хэрэв тухайн сарын орлого зарлагаас давж байвал танай өрхийн төсөв илүүдэлтэй байна гэсэн үг. Төсвийн илүүдлийг хадгаламжаа нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт хийх зэргээр зарцуулж болно.

Бүдүүвч 2. Өрхийн төсвийн тэнцэл



Харин зарлага тань орлогоосоо давчихвал төсвийн алдагдал буюу мөнгөний нэмэлт хэрэгцээ үүснэ. Энэ тохиолдолд дараах арга хэмжээнүүдийг авч болно. Үүнд:

- Төсөвлөсөн зардлуудаа дахин хянаж, хэмнэж болох зардал байвал түүнийг багасгаж төлөвлөх;
- Дараа сар хүртэл хойшлуулж болох зардлыг хасах;
- Орлогоо нэмэгдүүлэх өөр боломжуудыг эрж хайх;
- Зардлаа бууруулах боломжгүй бол ямар эх үүсвэрээр санхүүжүүлэхээ шийдвэрлэх. Тухайлбал, гэнэтийн хэрэгцээнд зориулсан мөнгөн хөрөнгийн нөөцөө ашиглах, эсвэл зээл авах гэх мэт.

ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН


Дэлхийн зэсийн салбарын эрэлт, нийлүүлэлтэд Чили Улс болон БНХАУ голлох нөлөө үзүүлж байна. Тухайлбал Чили Улс зэсийн нөөц болон олборлолтоор тэргүүлж, 2016 онд дэлхийн зэсийн нийлүүлэлтийн 23 хувийг дангаараа бүрдүүлсэн. Харин БНХАУ зэсийн хамгийн том хэрэглэгч буюу хүдэр, цэвэршүүлсэн зэсийн импортоор тэргүүлдэг. Зэс цэвэршүүлэлтээр БНХАУ, Чили болон Япон Улс тэргүүлдэг бол цэвэршүүлсэн зэсийн экспортоор Чили, Замби улсууд тэргүүлж байна. Зэсийн арилжаа хийгддэг үндсэн биржүүд нь АНУ-ын Comex, ИБУИНВУ-ын LME, БНХАУ-ын SHFE байдаг. Дэлхийн хэмжээнд хэрэгжиж буй томоохон төслүүдийн төлөвлөгөөний дагуу 2017-2021 онуудад зэсийн нийлүүлэлтийн хэмжээ жилд дунджаар 0.5 сая тонноор нэмэгдэх төлөвтэй байна.

Дүрслэл 1. Зэсийн нийт нөөц /2015 он/



(Эх сурвалж: ICSG, World Copper Factbook)


Дүрслэл 2. Зэс олборлолтоор тэргүүлэгч орнууд, сая тонн /2016 он/




(Эх сурвалж: USGS, Mineral Commodity Summaries)

Дэлхийн зэсийн эрэлт 2016 онд 23.4 сая тонн байж, үүний 45 хувийг БНХАУ дангаараа бүрдүүлсэн. Тус улсын 2020 он хүртэл баримтлах эрчим хүчний салбарын шинэчлэл, хотжилтыг дэмжих, хуучин орон сууцыг шинэчлэх зэрэг бодлогоос шалтгаалан БНХАУ-ын зэсийн эрэлт 2017 онд 4 хувиар, 2020 он хүртэл жил бүр 2 хувиар өсөх хүлээлттэй байна. Мөн Евро бүсийн орнуудын зэсийн хэрэглээ барилгын болон автомашины үйлдвэрлэлийн салбарт өсөх төсөөлөлтэй байна.

Дүрслэл 3. Зэсийн үнийн төсөөлөл,



Дүрслэл 4. Дэлхийн зэсийн хэрэглээ, салбараар /2015 он/




Чили болон Индонези Улсад орших дэлхийн хамгийн том уурхайнуудад саатал гарсан, БНХАУ эдийн засгийн өсөлтийн төлөвөө бууруулсан, Лондонгийн металлын биржийн агуулахын нөөцийн хэмжээ сүүлийн 20 жилд байгаагүйгээр нэмэгдсэн, АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ өсгөсөн зэрэг нь зэсийн үнэ сүүлийн саруудад хэлбэлзэл ихтэй байхад нөлөөлөв.

Олон улсын шинжээчид 2017 онд зэсийн үнэ буурч, 1 тонн зэс 5500 ам.долларт хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна. Энэ нь нийлүүлэлтийн хэмжээ эрэлтийн хэмжээнээс 160 мянган тонноор илүү байх төсөөлөл, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал болон баримталж буй бодлого, АНУ-ын ХНБ-наас бодлогын хүүгээ 2017 онд дахин 2 удаа өсгөх магадлал, агуулах дахь зэсийн нөөцийн хэмжээ хурдацтай өсч буй зэргээс шалтгаалж байна.

Монгол Улс зэсийн нөөцийн хэмжээгээр дэлхийд 12 дугаарт, зэсийн олборлолтын хэмжээгээр 17 дугаарт, зэсийн хүдрийн экспортоор 5 дугаарт бичигджээ. Энэ нь зэс олборлогч ихэнхи орнууд зэсийн хүдэр бус цэвэршүүлсэн зэс экспортлодогтой холбоотой. Зэсийн салбар нь 2016 онд 1.5 сая тонн зэсийн баяжмал экспортлон 1.7 тэрбум ам.долларын экспортын орлогыг бүрдүүлж, нийт экспортын 36 хувийг дангаараа эзэлсэн. Зэсийн экспортын 62 хувийг “Оюу Толгой” ХХК, 30 хувийг “Эрдэнэт Үйлдвэр” ХХК тус тус эзэлдэг. Үнийн бууралтаас үүдэн 2017 онд зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 1.3 сая тоннд хүрч, экспортын орлого 1.4 тэрбум ам.доллар байх төсөөлөлтэй байна. Ингэснээр зэсийн салбар нийт экспортын орлогын 31 хувийг бүрдүүлэн, 2016 оны үзүүлэлтээс 5 нэгж хувиар буурах хүлээлттэй байна.

Дүрслэл 5. Зэсийн хүдрийн экспорт, улсаар /2014 он/



(Эх сурвалж: ОЕС, Copper ore trade)

Дүрслэл 6. Барилгын салбарын зэсийн хэрэглээ, улс орнуудаар, мян.тонн /2015 он/



(Эх сурвалж: GFMS Copper Survey)

Хүснэгт 1. Дэлхийд тэргүүлэх 10 уурхай /2016 он/

	Уурхайн нэр	Байршил	Хүчин чадал /мян.тонн/
1	Escondida	Чили	1,200
2	Grasberg	Индонези	780
3	Morenci	АНУ	520
4	Buenavista del Cobre	Мексик	510
5	Collahuasi	Чили	500
6	El Teniente	Чили	452
7	Antamina	Перу	450
8	Los Bronces	Чили	435
9	Polar Division	ОХУ	430
10	Los Pelambres	Чили	420

Бэлтгэсэн: И.Мөнхзул (ЗЗГ-ын эдийн засагч)



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ДАРЬГАНГА ЭМЭГТЭЙН ТОЛГОЙН БООЛТ A DARIGANGA WOMAN'S HEAD GARMENT

Толгойн өмсгөл татуур: 18 x 3.5 см

Үсний хавчаар: 7.2 x 5.2 см

Жин: 6425.0 гр

587 ширхэг шүр

"Tatuur" Head garment: 18 x 3.5 cm

Hairclips: 7.2 x 5.2 cm

Weight: 6425 gr

587 corals

1697 онд Манжийн хааны зарлигаар Монголын зүүн хэсэг Дарьгангад халх, өөлд болон цахарын хошуунаас анх хүн хүч гаргуулан, хааны төмөр сүргийг хариулах болсон юм. Ийнхүү хааны төмөр сүргийг хариулах халх болон цахар нарыг XX зуун хүртэл бусад ястнаас ялган, хааны төмөр сүрэгчин, Дарьгангачууд хэмээн нэрлэсээр ирсэн ажээ.

Дарьгангачууд эзэн хааны сүргийг хариулсны хөлсөнд мөнгө, шүр авдаг байсан тул хувцас чимэглэл нь шүр шигтгэсэн, мөнгөн хийцтэй байв. Ялангуяа эхнэр хүний толгойн гоёл болох татуур, хавчаар, шивэргэлийг дан шүрээр чимэглэж урладаг байснаас Сүргийн хүүхэн шүрэнд, Халхын хүүхэн гаансанд гэх яриа гарсан байдаг.

Энэхүү Дарьганга эмэгтэйн толгойн татуур нь шүрэн шигтгээ бүхий алт шармал мөнгө бөгөөд хоёр шанаанаас таван давхар шүрэн сагалдрагатай. Мөн таван мөнгөн бөнжигнүүр бүхий шүрэн унжлагатай ажээ.

In 1697, through an edict issued by the Qing Dynasty Emperor, the first herders of the eastern Dariganga region were selected and sent from the Khalka and Tsakhar Mongolia to herd the Emperor's herd of horses. These herders came to be called the Dariganga people.

These herders were paid in silver and coral for herding and tending to the horses. As a result, the Dariganga clothing and ornamentation featured an abundance of coral and silver. An especially ornamented Dariganga married woman's headdress consisted of the head garment "Tatuur", hair clips and "Shivergel" (a type of hair ornament that featured three rows of coral within a rectangular shape) were adorned only in corals, the expression "Herder woman to coral, Khalkha woman to tobacco" arose.

This Dariganga woman's "Tatuur" feature coral inlays, gilt gold, and five strands of coral that hang from the "Tatuur".

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИ (АУК) ОЛОН УЛСАД

Эхэн үеийн АУК			Азийн Хямрал болон түүний дараа				2008 оны хямралаас хойшхи АУК		
АУК	RTC	Securum	KAMCO	IBRA	Danaharta	SDIF	NAMA	AMCON	SAREB
Улс	АНУ	Швед	Солонгос	Индонези	Малайз	Турк	Ирланд	Нигер	Испани
Байгуулсан огноо	1989	1993	1997	1998	1998	1999	2009	2010	2012
Хууль эрх зүйн үндэс	АУК-ийн тухай хууль	Компаний тухай хууль	АУК-ийн тухай хууль	Ерөнхийлөгчийн зарлиг, Банкны тухай хууль	Компаний тухай хууль	Компаний тухай хууль	АУК-ийн тухай хууль	АУК-ийн тухай хууль	АУК-ийн тухай хууль
Эзэмшил	Төр	Төр	Хувийн хэвшил: 47.2%, Төр: 42.8%	Төр	Төр	Төр	Хувийн хэвшил: 51%, Төр: 49%	Төр	Хувийн хэвшил
Үндсэн зорилго	Жижиг банкуудын асуудлыг шийдэх	Төрийн эзэмшлийн Nordenbanken-ийн чанаргүй зээлийг шийдвэрлэх	Чанаргүй зээлийг худалдан авах, шийдвэрлэх	Хүндрэлд орсон банкуудыг шийдвэрлэх, хадгаламжийг даатгах, зориулалтын бусаар ашиглагдсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дэмжлэгийг эргүүлж татах	Чанаргүй зээлийг худалдан авах, удирдах, шийдвэрлэх; хаагдсан/ да-мпуурсан хоёр банкны эрх хүлээн авагч	Хүндрэлд орсон банкуудыг шийдвэрлэх, хадгаламжийн даатгал, зориулалтын бусаар ашиглагдсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дэмжлэгийг эргүүлж татах	Чанаргүй зээлийг худалдан авах, удирдах, шийдвэрлэх	Чанаргүй зээлийг худалдан авах, удирдах, шийдвэрлэх; хаагдсан/ да-мпуурсан банкыг дахин хөрөнгөжүүлэх	Чанаргүй зээлийг худалдан авах, удирдах, шийдвэрлэх
Үйл ажиллагаа явуулах хугацаа	7 жил	Тодорхой заагаагүй, 10-15 жил гэж тооцоолсон ч 5 жил болсон	Тодорхой заагаагүй	6 жил	7 жил	Тодорхой заагаагүй	15 жил гэж тооцоолсон	Тодорхой заагаагүй	15 жил
Чанаргүй зээлийг бүртгэлийн үнээс хямдруулсан хэмжээ	Мэдээлэл байхгүй	Мэдээлэл байхгүй	64%	Мэдээлэл байхгүй	54%	Мэдээлэл байхгүй	57%	54%	52.4%
Чанаргүй зээлийн эргэн төлөлт	87% (зөвхөн активд)	Мэдээлэл байхгүй	46.8%	22% (зөвхөн чанаргүй зээл)	58%	16% (Зөвхөн чанаргүй зээлийн борлуулалт)	~33% (2014 оны төгсгөлд)	Мэдээлэл байхгүй	Мэдээлэл байхгүй

Эх үүсвэр: Public Asset Management Companies: A Toolkit (IBRD, World Bank, 2016)



ЖОН БЕЛЛ: БЭЛЭН БУС ГҮЙЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭНД ҮСРЭНГҮЙ АХИЦ ГАРЧ БАЙНА

“Банкир” булангийн энэ удаагийн ярилцлагад ХААН банкны Гүйцэтгэх захирал Жон Беллийг урьж, ярилцлаа.

■ Монголын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдлын тухай таны бодлыг сонсьё. Эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй буй өнөөгийн нөхцөлд арилжааны банкууд хэрхэн ажиллаж байна вэ, тухайлбал танай банк?

Монголын банкны салбарын өнөөгийн байдал харьцангуй тогтвортой байна гэж үзэж байна. Хэдий эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан банкуудын зээлийн чанарын үзүүлэлтүүд муудаж байгаа ч банкуудын төлбөрийн чадвар харьцангуй өндөр байгаа нь сайн үзүүлэлт юм. Монголбанкнаас тавьсан шаардлагын хүрээнд банкууд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө 25%-иас дээшхи хөрөнгийг хөрвөх чадвар сайтай активд байршуулах шаардлагатай байдаг бол томоохон арилжааны банкууд энэ харьцааг 40-өөш дээш хувиар ханган ажиллаж байна. ХААН Банкны хувьд эдийн засгийн хүндрэл

бэрхшээлтэй өнөөгийн нөхцөл байдалд эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна. Тухайлбал, үүнд зээлийн эрсдэлийн удирдлага, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагуудыг дэлхийн стандартын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд бүхий л эрсдлийг тодорхой түвшинд зөв удирдсанаар эдийн засгийн энэ хүндрэлтэй үед харилцагчид, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг найдвартай хамгаалж байна. Эдийн засгийн өсөлтийн хурд удааширч, бизнесийн идэвхжил багассан хэдий ч ХААН Банк энэ хугацаанд харилцагчийн үйлчилгээг сайжруулах ажлыг шат дараалан авч хэрэгжүүлж байна. Бид харилцагчиддаа зориулан 24 цагийн турш өөртөө үйлчлэх Экспресс банкны үйлчилгээг Монголд анхлан нэвтрүүлж, Интернэт банк, Мобайл банк, Ухаалаг банк зэрэг цахим банкны үйлчилгээг сайжруулж, харилцагч



нарын цаг хугацааг хэмнэх үйлчилгээг бий болгохын тулд ажиллаж байна. Мөн энэ жилээс эхлэн зээл авахыг хүссэн харилцагчдын хувьд зээлийн судалгааг түргэн шуурхай олгоход анхаарч хэрэглээний зээл, бизнесийн зээлийг шуурхай олгож байна. Бид эдийн засгийн нөхцөл байдал бэрхшээлтэй байна гээд гараа хумиад суулгүй, эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг тэтгэх зорилгоор зээлийн нөхцөлүүдээ уян хатан тогтоож, зээлийн хугацааг уртасгах, нөхцөлүүдийг хөнгөвчлөх зэрэг ажлуудыг хийж байна.

■ **Монгол Улс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдахаар болсон. Үүнтэй холбоотойгоор банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийнэ гэж байгаа. Үүнд та ямар байр суурьтай байгаа вэ?**

Юуны өмнө засгийн газар ОУВС-ийн “Өргөтгөсөн

санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах шийдвэр гаргаж, эдийн засгийг тогтворжуулах алхмыг авч хэрэгжүүлж байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд хамгийн оновчтой шийдвэр байсан гэж үзэж байна. Хөтөлбөрт хамрагдах шийдвэр гарсны дараа олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд ч Монголд итгэх итгэл сэргэж, хөрөнгө оруулах сонирхол ч харьцангуй нэмэгдсэнийг дурьдах нь зүйтэй байх. Энэхүү хөтөлбөртэй холбоотойгоор банкны салбарт “Активын чанарын үнэлгээ” /Asset quality review/ хийх асуудал тавигдсан. Манай ихэнх томоохон арилжааны банкууд жил бүр олон улсын аудитын компаниар санхүүгийн тайлангаа аудит хийлгэдэг, зарим банкуудын хувьд олон улсын бүртгэлийн стандартыг хэрэгжүүлдэг учраас энэхүү үнэлгээг хийлгэхэд ямар нэгэн асуудал гарахгүй гэж бодож байна. ХААН Банкны хувьд ч олон улсын аудитын компаниудтай хамтран ажиллаж, зөвхөн санхүүгийн тайлан дээр төдийгүй үйл ажиллагааны хувьд ч аудит тогтмол хийлгэдэг, мөн олон улсын бүртгэлийн стандартыг мөрдөж, актив хөрөнгөө олон улсын стандартын дагуу үнэлж ирсэн учраас “Активын чанарын үнэлгээ” хийлгэхэд нэг их зөрүү гарахгүй болов уу гэж бодож байна.

■ **ХААН Банкнаас олгож буй зээлийн хүү дунджаар хэд байгаа вэ. Монголд зээлийн хүү өндөр байна гэх шүүмжлэл их байдаг. Таны бодлоор зээлийн хүүг бууруулах ямар боломж байна вэ?**

Хамгийн сүүлийн байдлаар ХААН Банкны олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 19,6 хувь, ам.долларын зээлийн дундаж хүү 11,3 хувьтай байна. Монголын хувьд зээлийн хүү өндөр байна гэх шүүмжлэл их байдаг. Гэхдээ зээлийн хүү өндөр байгаа нь зөвхөн банкны салбарын шийдэх асуудал биш юм. Зээлийн хүүг тодорхойлоход маш олон хүчин зүйлс нөлөөлдөг. Макро эдийн засгийн талаас авч үзвэл тухайн улсын зээлжих зэрэглэл, инфляци, төгрөгийн ханшийн тогтвортой байдал, улсын валютын нөөц, мөнгөний болон төсвийн бодлого зэрэг хүчин зүйлс нөлөөлөхөөс гадна банкны салбарын өрсөлдөөн, хадгаламжийн хүү, хүмүүсийн хуримтлалын хэмжээ, зээлийн эрэлт гээд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Банкууд зээлийн үнэлгээг хийхдээ зах зээлийн хүчин зүйлс, өрсөлдөөний нөхцөл байдал, зээлдэгчийн санхүүгийн болон зээлжих чадвар, зээлийн зориулалт, эх үүсвэрийн өртөг, зээлийн хугацаа, үйл ажиллагааны зардал, зорилтот ашиг, эрсдэлийн

түвшин зэрэг хүчин зүйлсийг харгалзан, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоодог. Монголын банкуудын зээлийн багцын 80 гаран хувийг төгрөгийн зээл эзэлдэг бөгөөд төгрөгийн эх үүсвэрийн дундаж өртөг ойролцоогоор жилийн 13.0% орчим, хугацаа нь 1 жилээс бага байгаа бол чанаргүй зээлийн хувь 7.1% орчим байна. Тэгэхээр Монголын банкуудын зээлийн хүүнд гол нөлөөлж буй хүчин зүйлс нь эх үүсвэрийн зардал, зээлийн эрсдэл байдаг. Зээлийн хүү буурахын тулд хамгийн түрүүнд макро эдийн засаг тогтвортой, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болсон байх шаардлагатай болов уу. Монгол улсын засгийн газар ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдах болсон нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход маш чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Эдийн засгийн тогтвортой байдал бий болсноор Монгол улсын зээлжих зэрэглэл сайжирч, С зэрэглэлээсээ В зэрэглэл рүү орвол гаднаас орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхээс гадна олон улсаас татах хөрөнгийн өртөг, хүүгийн зардал багасах боломжтой болох юм. Энэ үед Монгол улсын валютын нөөц нэмэгдэж, валютын ханш тогтвортой болох бөгөөд улмаар төгрөгийн хүү буурах боломж бүрдэнэ гэж харж байна.

■ **ХААН Банк Монголд хамгийн олон харилцагчтай гэдэг. Тэр хэрээр банкны үйлчилгээг түргэн, шуурхай хүргэхэд ч онцгой анхаарч ажилладаг байх. Энэ талаар танай банк ямар менежмент хэрэгжүүлж байна вэ?**

ХААН Банк нь Монгол орны өнцөг буланг бүрт байрлах салбар нэгжээрээ дамжуулан харилцагчиддаа хүрч үйлчилдэг. Бид завгүй өнөөгийн нийгэмд харилцагчиддаа банкны үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хүргэх үүднээс цахим банкны хэрэглээг нэмэгдүүлж, теллерийн гүйлгээний ачааллыг бууруулах чиглэлд голчлон анхаарч ажиллаж байна. Үүний үр дүнд орон даяар 100 гаруй Экспресс банк, 900 гаруй АТМ, 4500 гаруй Картаар Үйлчлэгч байгууллагууд, 6100 гаруй ПОС машинтай болж, дэвшилтэт технологи, цахим банкны үйлчилгээгээр салбартаа тэргүүлж байна. Хамгийн сүүлд гэхэд Монголд анх удаа QR кодоор төлбөр төлөх QRpay үйлчилгээг нэвтрүүлж, цахим банкаар тэргүүлэгч байр сууриа дахин нотоллоо. Мөн Монголд анх удаа эмэгтэйчүүдэд зориулсан Глэмор кредит картыг зах зээлд нэвтрүүллээ. Мөн банк, нийтийн тээвэр хосолсон Сити пасс картыг зах анхлан

“ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах шийдвэр гаргаж, эдийн засгийг тогтворжуулах алхмыг авч хэрэгжүүлж байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд хамгийн оновчтой шийдвэр байсан гэж үзэж байна.”

нэвтрүүлснээр харилцагчид маань Сити пасс картаараа банкны төлбөрийн картаар авдаг бүх үйлчилгээг аваад зогсохгүй автобусанд давхар зорчиж байна.

■ **Монголбанкнаас “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ” аяныг эхлүүлсэн байгаа. Иргэдийн мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээг дэмжихэд бэлэн мөнгөний хэрэглээг аль болох бууруулах, цахим төлбөрийн хэрэгслийг ашиглах нь чухал. Монголын банкууд ч бас аль болох цахим төлбөр тооцоо, гүйлгээг өргөн хүрээнд нэвтрүүлэхэд анхаарч байгаа. ХААН Банкны хувьд энэ талын үйлчилгээгээ хэрхэн өргөтгөхөөр төлөвлөж байна вэ?**

Манай банк орлого зарлагын ухаалаг АТМ-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд багагүй хугацаа өнгөрлөө. Харилцагчид маань энэ хугацаанд орлого, зарлагын АТМ-ыг ашиглаж санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай авч байна. Гэхдээ АТМ-д орлого хийж буй мөнгөн тэмдэгтийн чанар байдал сайнгүй нь ажиглагдаж



“Мөнгөн тэмдэгт нь тухайн улс орны түүх, тусгаар тогтнол, соёлыг харуулсан нэгэн том үнэт зүйл юм.”

байна. Бид орлого, зарлагын АТМ-аараа дамжуулан муудсан мөнгөн тэмдэгтийг цуглуулан Төв банкинд тушаахад багагүй үүрэг гүйцэтгэж байна. ХААН Банкны зүгээс өөрийн харилцагчдын бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах тал дээр өөрсдийн үйл ажиллагааны бүхий л сувгаар идэвхтэй сурталчилж, хэрэглэж хэвшихэд нь сургасаар ирсэн. Үүний үр дүнд цахим банкны хэрэглэгчдийн тоо улам бүр өссөөр байна. Монголбанк болон ХААН Банкны мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээг дэмжих зорилго нэг байгаагийн тод илрэл нь бид өөрсдийн үйлчилгээний хамгийн хямд, хялбар сувгийг цахим хэрэглээ болгохоор зорьж ажиллаж буйгаар илэрч байна. Өнөөдрийн байдлаар теллер, цахимын гүйлгээний харьцаа 85:15 болж, бэлэн бус гүйлгээний хэрэглээнд үсрэнгүй ахиц гарч байна.

■ **ХААН Банкны нэг давуу тал нь иргэдтэй хамгийн ойр, тулж ажилладаг. Энэ утгаараа Монголчуудын мөнгөн тэмдэгтэд хандаж буй хандлагыг тодорхой хэмжээнд ажиглаж, дүгнэж байдаг болов уу. Та мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээний талаар Монголчуудад хандаж уриалга хэлнэ үү?**

Мөнгөн тэмдэгт нь тухайн улс орны түүх, тусгаар тогтнол, соёлыг харуулсан нэгэн том үнэт зүйл юм. Энэ утгаараа ч мөнгөн тэмдэгтийг хэвлүүлэх, гүйлгээнд оруулахад их хэмжээний хөрөнгө мөнгө ордог. Тиймээс иргэд та бүхэн улсынхаа мөнгөн тэмдэгтийг хайрлан хамгаалж, түүнийг зөв зохистой, соёлтой хэрэглэхийг уриалж байна.

Ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: Л.Энхдэлгэр (ОНБМТ-ийн мэргэжилтэн)

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКСИЙН 2017 ОНЫ I УЛИРЛЫН ҮР ДҮН


Эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг байгааг “Хэрэглэгчийн итгэлийн индекс” (ХИИ) хэмждэг. ХИИ-ийн утга 100-гаас өндөр бол хэрэглэгчид өөдрөг, харин 100-гаас бага бол гутранги байгааг харуулна. Харин 100 гэсэн үзүүлэлт нь хэвийн гэсэн утгыг илэрхийлдэг. Хэрэглэгчийн итгэлийн индекс судалгаагаар хэрэглэгчийн итгэлийн талаарх үзүүлэлтүүдээс гадна эдийн засгийн гол үзүүлэлтүүд болох өрхийн зарлагын өөрчлөлт, инфляци болон ханшийн хүлээлтийн талаар нэлээд бодитой мэдээлэл гаргадаг болох нь судалгааны тайлангуудаас харагддаг. Үзүүлэлтүүдийг хэрэглэгчдийн шинж чанар болон бүс нутгаар харах боломжтой.

Монгол Улсын хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2017 оны 1-р улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 6.9 пунктээр өсч 78.1 болсон байна. ХИИ-ийн энэ


өөрчлөлтөд түүний бүрэлдэхүүн хэсэг болох өнөөгийн байдлын индекс болон хүлээлтийн индексийн өсөлт нөлөөлсөн. Тухайлбал, ирээдүйн хүлээлтийн индекс жилийн өмнөх түвшнээсээ 6.9 пунктээр өсч 112.9 болжээ. Харин өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үед 18.9 байсан бол жилийн хугацаанд 7.0 пунктээр (37.4%) өсч 25.9 болжээ.

Өнөөгийн байдлын индексийн өсөлтөд бизнесийн нөхцөл байдал сайн (7.4 пункт) болсон болон ажлын олдоц сайжирсан (6.3 пункт) нь нөлөөлжээ. Ойрын ирээдүйд буюу ирэх 6 сарын хугацаанд эдийн засгийн байдал ямар байх талаар өрхийн хүлээлт сайжирсан нь, тэр дундаа бизнесийн нөхцөл (14 пункт) болон орлогын индексийн өсөлт (20.9 пункт) гол нөлөө үзүүлсэн байна. Харин ажлын олдоцны талаарх хүлээлт буурсан (19.6 пункт) байна.

Зураг 1. ХИИ ба ДНБ



Зураг 2. ХИИ бүсээр




Худалдан авалтын төлөвлөгөө

Аялал жуулчлал болон удаан эдэлгээтэй бүтээгдэхүүнүүд болох үл хөдлөх хөрөнгө, томоохон эд хогшил, автомашин зэрэг нь эрэлтийн мэдрэмж өндөртэй байдаг. Эдийн засгийн хэлбэлзлийн талаарх

тогтсон баримтаас үзвэл эдгээр бүтээгдэхүүний хэрэглээний зардал нь эдийн засгийн мөчлөгийн дагуу өөрчлөгддөг ба өөрчлөлтийн хэмжээ нь ДНБ-ий өөрчлөлтөөс хэд дахин их буюу далайц ихтэй байдаг.

Зураг 3. Худалдан авалтын төлөвлөгөө



Жишээлбэл, эдийн засгийн уналтын үед хэрэглэгчид юуны өмнө автомашин, цахилгаан бараа зэрэг удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний хэрэглээний зардлыг бууруулдаг. Иймд удаан эдэлгээтэй бараа бүтээгдэхүүн худалдан авахаар хэрэглэгчдийн төлөвлөж буй зардал нь эдийн засгийн төлөв байдлын талаар чухал мэдээлэл агуулдаг. Зураг 3 хэрэглэгчдийн худалдан авалтын

төлөвлөгөөг 2017 оны 1-р улирлын байдлаар харуулж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үл хөдлөх хөрөнгө, автомашины худалдан авалтын төлөвлөлт мэдэгдэхүйц нэмэгдэж, аялал жуулчлалын төлөвлөлт мэдэгдэхүйц буурсан байна.

Эх сурвалж: NRCC



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС БОЛОН МОНГОЛ УЛС ХООРОНДЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын сан нь дэлхий дахинд иргэдтэй шууд харьцах банкны ажилтнуудыг чадавхижуулах замаар олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх сургалт хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч орны эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахыг гол зорилгоо болгодог. Энэхүү зорилгын хүрээнд "Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хосолсон сургалт, Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл"-ийг Монголбанктай хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн үндсэн зорилго:

1. Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалтын стандарт тогтоох;
2. Банкны удирдах түвшний ажилтнуудад зориулсан

мэргэжлийн семинар зохион байгуулж, явуулах;

3. Монгол Улсад дэлхийн хуримтлалын өдрийг танилцуулж, нэвтрүүлэх.

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш гарсан дэвшил болон явц:

Төсөл албан ёсоор 2016 оны 11-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд дараах ажлууд хийгдэв. Үүнд:

- 2016 оны 12-р сард тус сургалтыг заах 11 сургагч багш нарыг Германд (Потсдам) бэлтгэв.
- Нийт 16 сургагч багшийг 2017 оны 04-р сарын 3-14-ний өдрүүдэд сургалтанд хамруулж бэлтгэв.
- Нийт 11 удирдагч багшийг /арилжааны банкуудаас/ 2017 оны 04-р сард бэлдэв.
- ХБНГУ-ын Нассау хотын Хадгаламжийн банкнаас (Nassauische Sparkasse) Хүний нөөцийн мэргэжилтэн Анна Петчулат хүрэлцэн



ирж менторын сургалтыг 2017 оны 4 сарын 19-21-ний өдрүүдэд Монгол улс дахь төслийн багтай хамтран зохион байгуулсан. Арилжааны 14 банкнаас 11 банкны төлөөлөл сургалтанд хамрагдаж менторын эрхээ гардаж авав.

- Хүний нөөцийн хэлтсийн удирдлагуудад зориулсан “Банкны хүний нөөцийг удирдахад тулгарч буй бэрхшээл, орчин үеийн чиг хандлага” сургалтыг 5-р сарын 3-4-ний өдөр зохион байгуулав (арилжааны банкны нийт 27 оролцогчтой).





ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БОЛЛОО

Олон улсын валютын сангийн захирлуудын зөвлөл 2017 оны 5-р сарын 24-ний өдөр хуралдаж, Монгол Улсад зориулж 3 жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг батлах шийдвэр гаргалаа. Хөтөлбөр батлагдсанаар эхний ээлжинд 38.6 сая ам.долларын санхүүжилт Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкинд орж ирээд байна.

Монгол Улсад эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх тус хөтөлбөрийн хүрээнд хийгдэх нийт 5.5 тэрбум ам.долларын хэмжээтэй санхүүжилтэд ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка зэрэг олон улсын байгууллагуудаас гадна Япон, БНХАУ, БНСУ зэрэг 2 талт хамтын ажиллагааны орнууд оролцох болно.

Эдийн засгийг тогтворжуулах, зах зээл дээрх итгэлийг сэргээх зорилготой уг хөтөлбөрийн үр дүнд Монгол Улсад үнийн тогтвортой байдал хангагдах, валютын нөөц нэмэгдэж 4 тэрбум ам.доллар орчимд хүрэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжих, гадаад өрийн зохистой бүтэц, өрийн тогтвортой байдал хангагдах зэрэг эерэг өөрчлөлтүүд бий болохоор хүлээгдэж байна.

Түүнчлэн, Монголбанкны засаглалыг сайжруулах, бие даасан байдлыг бэхжүүлэх, Монгол Улсад санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн шинэчлэлүүд хийгдэх болно. Тухайлбал, Төв банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд төв банкны бие даасан, хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан орчныг бүрдүүлэх, Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд банкинд хүндрэл үүссэн үед асуудлыг түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх боломжийг дээшлүүлэх юм.

Банкны секторын тогтвортой байдлыг хангах үүднээс арилжааны банкуудад активын чанарын үнэлгээг (AQR) хийх бөгөөд ингэснээр банк, санхүүгийн системийн нөхцөл байдлыг нарийвчлан үнэлэх, улмаар санхүүгийн зуучлалыг өргөжүүлэхэд шаардлагатай байгаа арга хэмжээг тодорхойлох боломжтой болох юм. Банкны системийн эрүүл, найдвартай үйл ажиллагаа нь цаашид хувийн секторын дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад эерэг нөлөө үзүүлэх болно.



ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль (1996 он)-иар төрөөс баримтлах мөнгөний бодлогыг жил бүр УИХ-аар тодорхойлон батлуулж, мөнгөний бодлогын эцсийн шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч ганцаар гаргадаг, Засгийн газарт олгох санхүүжилтыг нарийвчлан зохицуулаагүйгээс гадна аливаа хязгаарлалтгүй байна. Төв банкны бие даасан, хараат бус байдлын үзүүлэлтийг тооцсон индексийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх үүднээс Монголбанкны үндсэн зорилтыг дэлхийн нийтийн түгээмэл, чиг хандлага болсон “Үнийн тогтвортой байдал” болгон өөрчлөх, мөнгөний бодлогыг УИХ-аас баталсан хуульд заасан “мөнгөний бодлогын үндсэн чиглэл”-ийн дагуу Монголбанкнаас тодорхойлдог болохоор тусгав.

Монголбанкнаас баримтлах мөнгөний бодлогын зорилтыг тодорхойлж, мөнгөний бодлогын хэрэгслийн хүү, банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоох эрх бүхий “Мөнгөний бодлогын зөвлөл” байгуулахаар тусгаж, төсвийн шинж чанартай санхүүжилт-хөтөлбөрийг Монголбанкнаас санхүүжүүлж, мөнгөний бодлогын зорилт үр нөлөөг алдагдуулдаг байдлыг арилгах зорилгоор Засгийн газарт зээл олгох, Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах Монголбанкны үйл ажиллагааг тодорхой зааж, хязгаарлалтыг тусгасан.

Монголбанкны удирдлага буюу Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг албан тушаалд томилох шалгуур, чөлөөлөх үндэслэл журмыг тогтоов.

МӨНГӨН ТЭМДЭГТИЙН НУУЦЛАЛ, ТАНИХ ТЭМДЭГ

2006 оны 20000-тын дэвсгэрт



Дэвсгэр зургийн зүүн доод талын босоо, хэвтээ ирмэгийн дагуу "MONGOLBANK" гэсэн үгийг маш **жижгээр бичсэн**.

Холограмм дардас дотор, Соёмбо үсэг, 20000-тын тоо **солонгорч харагдана**.



Дэвсгэртийн хоёр талд байрлах Чингис Хааны гэрэгэгийн дээд хэсгийн дугуй дүрсүүд зөрүүгүй **давхцана**.



Дэвсгэртийн дэвсгэр зураг, ялангуяа "Монгол Улс" гэсэн эвхмэл бичиг, "20000" төгрөгийн нэрлэсэн үнийн тоо гарт мэдрэгдэхээр **товгор**.



Тусгай гэрлээр харахад Соёмбо үсгийн хүрээ Чингис Хааны хөрөг, 20000 гэсэн тоо **гэрэлтэнэ**.



Гурван мм-ийн өргөнтэй тасалдаж харагдах металл утсан дээр "MONGOLBANK" гэсэн үг, Соёмбо үсэг солигдож **харагдана**.



Дэвсгэртийн нүүрэн талын баруун хэсгийг гэрлийн эсрэг барьж харахад Чингис Хааны хөрөг, "МБ" гэсэн үсэг бүхий усан хээ тодорно.

Налуугаас харахад дөрвөн морьтон баатрын дүрс, дэвсгэр өнгө нь дөрвөн хэсэгт **тодорно**.

Хэрэв танд эргэлзээ төрвөл сэжигтэй дэвсгэртийг жинхэнэтэй нь харьцуулж үзээрэй.



Мөнгөн тэмдэгтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар авна уу: www.mongolbank.mn.
МОНГОЛ БАНК

